



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 121

Сүхбаатар

Комисс томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, 66 дугаар зүйлийн 66.1.11, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.5.3, 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.2022 оны 5 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулагдах төрийн жинхэнэ удирдах албан тушаалын сул орсон тоог нөхөх тусгай шалгалтыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга	Ч.Энхтуяа (Төрийн албаны Зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүн, аймаг дахь Төрийн аудитын газрын дарга)
Нарийн бичгийн дарга	Ш.Энхмаа (Төрийн албаны Зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)
Гишүүд	Э.Оюунболд (Төрийн албаны Зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн ИТХ-ын нарын бичгийн дарга)
	Б.Болорзул (Төрийн албаны Зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны, удирдлагын хэлтсийн дарга)
	Ч.Даваадорж (Төрийн албаны Зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүн, ахмад төрийн албан хаагчийн төлөөлөл)
Техникийн ажлын хэсэг	Ч.Гандүүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын ТЗУХ)

-ийн мэдээллийн технологи хариуцсан ахлах мэргэжилтэн)

Л.Баярсүрэн
(Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

2.Шалгалтыг зохих журмын дагуу зохион байгуулж, дүнг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн, шийдвэрийг холбогдох газарт хүргүүлж, хяналт тавьж ажиллахыг комиссын дарга /Ч.Энхтуяа/, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /Ш.Энхмаа/ нарт даалгасугай.

ДАРГА



Ө.СУВДАА